

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ. БОДЛОГЫН ХОРООДЫН УДИРДЛАГА**

### **Нэг. Бодлогын хороодын удирдлага**

1. Бодлогын хороодын удирдлага намын удирдлага байна.
2. Цаг үеийн нөхцөл байдлаас хамаарч гэнэтийн нийгэм, улс төр, эдийн засгийн асуудлаар яаралтай бодлого боловсруулах ажлыг зохион байгуулах үүрэгтэй.

### **Хоёр. Бодлогын хорооны даргын эрх, үүрэг Бодлогын хорооны дарга дараах эрх, үүрэгтэй:**

1. Бодлогын хороог төлөөлөх, бодлогын хорооны саналыг баталгаажуулж холбогдох байгууллагуудад танилцуулах эрхтэй,
2. Судалгааны ажлын хэсгийг байгуулах эрхтэй,
3. Бодлогын хорооны ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах эрхтэй,
4. Бодлогын хорооны хуралдааныг удирдан зохион байгуулах эрхтэй,
5. Бодлогын хорооны хуралдааны дэгийг тогтоох эрхтэй,
6. Бодлогын хорооны шийдвэрийг баталгаажуулах үүрэгтэй,
7. Бодлогын хорооны хуралдааныг тогтмол зохион байгуулах үүрэгтэй,

### **Гурав. Бодлогын хорооны гишүүдийн эрх, үүрэг Бодлогын хорооны гишүүн дараах эрх, үүрэгтэй:**

1. Бодлогын хорооны гишүүн намын аль ч байгууллагаас мэдээлэл шаардах эрхтэй,
2. Бодлогын хорооны хуралдаанд таслах эрхтэйгээр оролцох эрхтэй,
3. Бодлогын хорооны даргад нэр дэвшүүлэх давуу эрхтэй,
4. Бодлогын хорооны хуралдааны дэгийг мөрдөх үүрэгтэй,
5. Бодлогын хорооны хуралдаанд идэвхтэй оролцох үүрэгтэй,